

Монголын “Герман Судлал” Төвийг үүсгэн байгуулсан тухай товч мэдээ

Монголын “Герман Судлал” Төвийг эрдэмтэн, судлаач нар болон олон нийтийн санаачилгаар 2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн дэргэд үүсгэн байгуулсан билээ. Уг хурлаар Төвийн Дүрмийг баталж, Удирдах Зөвлөлийг сонгосон юм.

Тус төвийн зорилго нь Монгол Улсад Герман судлалыг бүх талаар дэмжиж хөгжүүлэх, Германы нийгэм эдийн засгийн хөгжил, дэвшил, шинжлэх ухаан, соёл, боловсролын салбар дахь тэргүүний ололт амжилтыг өргөнөөр сурталчлан таниулахад тус дөхөм үзүүлэхэд оршино.

Энэ зорилгодоо хүрэхийн тулд Төв нь судалгаа, мэдээллийн чанартай “ГЕРМАН: Судалгаа, мэдээлэл” сэтгүүлийг хэвлэн нийтлүүлж, нийтийн хүртээл болгоно. Мөн тодорхой сэдэв, төслөөр дагнасан ба хамтарсан судалгаа хийх, судалгааны бүтээл туурвих, орчуулах, хэвлэн нийтлэх явдлыг төвлөрүүлж зохицуулна.

Төв нь түүний зорилго, үйл ажиллагааг дэмждэг хэн бүхэнд гишүүнээр элсэн ороход нээлттэй байна.

Өөрийн эрх хэмжээнийхээ хүрээнд үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу дотоод, гадаадын байгууллага, хувь хүмүүстэй ажил хэргийн холбоо тогтоож хамтран ажиллах, олон улсын төрөл бүрийн хурал, симпозиум, уулзалт, семинар зэрэг арга хэмжээнд идэвхтэй оролцож, мөн тийм арга хэмжээг Төв нь зохион явуулж байна.

Төвийн үйл ажиллагаа нь Монгол, Германы ард түмэн, олон нийтийн хооронд нөхөрсөг хэлхээ холбоо, тал бүрийн хамтын ажиллагааг бүхий л талаар дэмжин хөгжүүлэх улмаар улс орноо Герман ертөнцөд сурталчлан танилцуулах үйлсэд бүрэн чиглэгдэх юм.

Уг төвийн гишүүд болон дотоод, гадаадын талархан дэмжигч, ивээн тэтгэгч байгууллага, хамт олон, хувь хүмүүсээс оруулах хандив, судалгаа, сурталчилгааны бүтээл, хэвлэл нийтлэл, урлаг соёлын арга хэмжээ болон бусад үйлчилгээнээс